



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар  
сарын 5-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар  
хот

Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг  
эрчимжүүлэх зарим арга  
хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрөөс ахмад настны талаар баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт үүрэг болгосугай.

2. Геронтологийн үндэсний төвийн барилга, дэд бүтцийн ажлыг 2020 онд дуусгаж, ашиглалтад оруулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд, ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэхийг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт үүрэг болгосугай.


3. Монголын ахмадын холбоо, түүний салбар нэгжийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон тухайн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, төрийн болон нутгийн захиргааны зарим чиг үүргийг ахмадын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. “Ахмадын ордон” барих газрын асуудлыг шийдвэрлэж, зураг, төсөв зохиох ажлыг гүйцэтгүүлэх, уг ордныг барихад шаардагдах санхүүжилтийг 2020 оны орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэхийг нийслэлийн Засаг дарга С.Амарсайханд даалгасугай.

5. Орон байргүй ахмад настныг түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах, хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлэх, Ахмад настны тухай хуулийн 12.7 дахь хэсгийн хэрэгжилтийг ханган ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, “Ахмадын сан” байгуулан ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

6. Ахмад настны тухай хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, ахмад настанд залуучуудын үзүүлэх тусламж, дэмжлэг, туслалцааг нэмэгдүүлэх, тэдний туршлага мэдлэгээс суралцах, соён гэгээрүүлэх чиглэлээр Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлтэй хамтран ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хөдөлмөр, нийгмийн  
хамгааллын сайд

УХА0064

У.ХҮРЭЛСҮХ

С.ЧИНЗОРИГ